



**ОРХОН АЙМГИЙН
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2025 оны 01 сарын 21 өдөр

Дугаар 6/09

Баян-Өндөр сум

**Цалин, хөлсний хэмжээ шинэчлэн
батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.2, 57.2.4 дэх заалт, Улсын их хурлын 2019 оны 21 дүгээр тогтоол, Засгийн газрын 2022 оны 318, 2025 оны 238 дугаар тогтоол, Орхон аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 03/13 дугаар тогтоолын 3.2.14 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Худалдан авах ажиллагааны газрын албан хаагчдын албан тушаалын үндсэн цалин болон орон нутгийн нэмэгдлийн хэмжээ, өдрийн хоолны нэмэгдлийг хавсралтаар баталсугай.

2.Албан хаагчдын цалин хөлс бусад нэмэгдлийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс холбогдох журмын дагуу тооцож олгохыг нягтлан бодогч (Г.Бүдхүү)-д зөвшөөрсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөц, дотоод ажил хариуцсан ажилтан (Б.Ариунжаргал)-д даалгасугай.

4.Тус тушаал гарсантай холбогдуулан 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн Б/18 дугаартай тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.ОЮУНБАЯР

ЗАСГИЙН ГАЗРЫН АГЕНТЛАГ, НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА
БОЛОН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БУСАД БАЙГУУЛЛАГЫН ТӨРИЙН
ЗАХИРГААНЫ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ

(сард, төгрөгөөр)

Албан тушаалын зэрэглэл	Цалингийн хэмжээ
T3-1	2,586,000
T3-2	2,301,000
T3-3	2,171,000
T3-4	2,049,000
T3-5	1,862,000
T3-6	1,693,000
T3-7	1,539,000
T3-8	1,399,000
T3-9	1,283,000
T3-10	1,166,000

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУСАД БАЙГУУЛЛАГА БОЛОН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХАД ТУСЛАХ
АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ДООД ХЭМЖЭЭ

(сард, төгрөгөөр)

Албан тушаал	Цалингийн доод хэмжээ
ТҮ-12	1,804,000
ТҮ-11	1,718,000
ТҮ-10	1,636,000
ТҮ-9	1,558,000
ТҮ-8	1,417,000
ТҮ-7	1,340,000
ТҮ-6	1,276,000
ТҮ-5	1,160,000
ТҮ-4	1,105,000
ТҮ-3	1,052,000
ТҮ-2	1,003,000
ТҮ-1	954,000